



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/17

Сүхбаатар


Журам, маягт, заавар аргачлал, загвар
батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам"-ыг нэгдүгээр, нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах маягтуудыг хоёрдугаар, сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлалыг гуравдугаар, дүгнэлтийн загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журам, зааврыг хэрэгжүүлэн, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Батмөнх/-г даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

018010053

Дарга, тэргүүлэх аудиторын
20²⁰ оны 10 дугаар сарын 28-ны өдрийн
2020 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОЖ БАЙГАА НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН
ТАЙЛАН ГАРГАХ, ЗАРДЛЫН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХ, ХЯНАХ, ДҮНГ НИЙТЭД
МЭДЭЭЛЭХ, ТАНИЛЦУУЛАХ ЖУРАМ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг. Журмын зорилго

1.1. Энэ журмын зорилго нь Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн санхүүжилтээ хуулиар хүлээн зөвшөөрсөн, бодитой эх үүсвэрээс бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан талаар тайлагнах, түүнд дүгнэлт гаргах, сонгуулийн санхүүжилтийг сонгогч иргэн, олон нийтэд нээлттэй, ил тод байлгах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Журмын үйлчлэх хүрээ

2.1. Энэ журмыг Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн санхүүжилтийн хөрөнгийг хуримтлуулах, сонгуулийн зардал гаргах, сонгуулийн зардлын тайлан гаргах, сонгуулийн зардлын тайландаа аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулах, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулахад дагаж мөрдөнө.

2.2 Энэхүү журам нь тус журмын 16.4-д заасан маягт, 20.7-д заасан дүгнэлтийн загвар бүхий хавсралтаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ

Гурав. Сонгуулийн зардлын данс

3.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн /цаашид "хууль" гэх/ 50.1-д зааснаар сонгуульд оролцож байгаа нам, эвсэл болон нэр дэвшигч аймаг, суманд сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна.

3.2. Эвслийг төлөөлөх байгууллагын шийдвэрээр эвсэлд нэгдсэн нэг нам эвслийг төлөөлж эвслийн сонгуулийн зардлын данс нээлгэх ба эвслийг төлөөлөх байгууллагаас эрх олгогдсон этгээд эвслийн сонгуулийн зардлын данснаас зарлага гаргана.

3.3 Нам, эвсэл, нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай Сонгуулийн хорооны шийдвэр гарснаас хойш нам, эвсэл, нэр дэвшигч холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэж сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт бичгээр мэдэгдэж, бүртгүүлнэ.

Дөрөв. Сонгуулийн зардлын санхүүжилт

4.1. Нам, эвслийн сонгуулийн санхүүжилт нь намын өөрийн хөрөнгө, мөнгөн хандиваас бүрдэнэ.

4.2. Нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт нь намын өөрийн хөрөнгө, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, мөнгөн ба мөнгөн бус хандиваас бүрдэнэ.

4.3. Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт нь нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, мөнгөн ба мөнгөн бус хандиваас бүрдэнэ.

Тав. Сонгуулийн зардалд зарцуулах намын өөрийн хөрөнгө

5.1. Сонгуулийн зардалд зарцуулах намын өөрийн хөрөнгө нь Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу намын өөрийн дансанд хуримтлуулсан мөнгөн хөрөнгө байна.

5.2. Нам энэ журмын 5.1-д заасан хөрөнгийг өөрийн данснаасаа нам, эвслийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлэн зарцуулна.

5.3. Нам, эвсэл өөрийн нэр дэвшигчийн сонгуулийн зардалд зориулж олгох намын өөрийн хөрөнгийг нам, эвслийн сонгуулийн зардлын данснаас тухайн нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлэг хийж олгоно.

5.4. Нам, эвсэл сонгуулийн зардалд зарцуулах намын өөрийн хөрөнгийг бусдаас бэлэглэл, зээл хэлбэрээр авч бүрдүүлэхийг хориглоно.

Зургаа. Сонгуулийн зардалд зарцуулах нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө

6.1. Сонгуулийн зардалд зарцуулах нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан орлогод хамаарах мөнгөн хөрөнгө хамаарна.

6.2. Нэр дэвшигч энэ журмын 6.1-д заасан мөнгөн хөрөнгийг өөрийн данснаасаа сонгуулийн зардлын дансандаа байршуулж зарцуулна.

6.3. Нэр дэвшигч сонгуулийн зардалд зарцуулах өөрийн хөрөнгийг бусдаас бэлэглэл, зээл хэлбэрээр авч бүрдүүлэхийг хориглоно.

Долоо. Сонгуулийн хандив

7.1. Хуулийн 52.1-д зааснаар сонгуулийн хандив нь мөнгөн ба мөнгөн бус хэлбэртэй байна.

7.2. Хандив нь хандивлагчийн өөрийн хөрөнгө, үйл ажиллагааны орлогын чадамжаас даваагүй, бодитой байна.

7.3. Хандивлагч нэг нам, эвсэл, нэр дэвшигчид хандив өгсөн нь өөр нам, эвсэл, нэр дэвшигчид хандив өгөхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

7.4. Хандивлагч нэр дэвшигчид мөнгөн хандив өгсөн нь тухайн нэр дэвшигчид мөнгөн бус хандив өгөхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

7.5. Хуулийн 55.1-д заасан этгээд хандив өгөхийг хориглох ба нам, эвсэл, нэр дэвшигч шаардсан тохиолдолд хандивлагч нь уг шаардлагыг хангаж байгаа эсэхийг нотлох баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.

Найм. Мөнгөн хандив

8.1.Хандивлагч этгээдээс эргэж төлөх нөхцөлгүйгээр нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг мөнгөн хандив гэнэ.

8.2.Хуулийн 53.1-д заасны дагуу мөнгөн хандив нь иргэний хувьд хоёр сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд арван сая төгрөг хүртэл байна.

8.3.Нам, эвсэл, нэр дэвшигч нь мөнгөн хандивыг зөвхөн сонгуулийн зардлын дансанд хүлээж авна.

8.4.Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын данс хооронд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг хандивт тооцохгүй.

Ес. Мөнгөн бус хандив

9.1.Хандивлагч этгээдээс сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс дуусах хүртэл хугацаанд зөвхөн нэр дэвшигчид үнэ төлбөргүйгээр үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх, үйлчилгээ үзүүлэхийг мөнгөн бус хандив гэнэ.

9.2.Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх мөнгөн бус хандивын гэрээг тухайн эд хөрөнгийн өмчлөгч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдтэй байгуулна.

9.3.Үйлчилгээ үзүүлэх мөнгөн бус хандивыг тухайн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, эсхүл төлөөлөх эрх бүхий этгээдтэй байгуулна.

9.4.Хуулийн 55.5-д заасны дагуу нам өөрийн өмчлөлийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглуулж болох бөгөөд энэ нь хандивт тооцогдохгүй.

Арав. Мөнгөн бус хандивын үнэлгээг тодорхойлох

10.1.Мөнгөн бус хандивын зах зээлийн дундаж үнэлгээг дараах журмаар тодорхойлно:

10.1.1.тухайн эд хөрөнгө ашиглуулсан, эзэмшүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн хандивлагч энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг бол уг үйл ажиллагааны дундаж үнэлгээгээр;

10.1.2.тухайн эд хөрөнгө ашиглуулсан, эзэмшүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн хандивлагч энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагааг эрхэлдэггүй бол тухайн газар нутаг дахь энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн үнийн дундаж үнэлгээгээр.

10.2.Мөнгөн бус хандивын үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгч болох мөнгөн хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

Арван нэг. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив

11.1.Дараах хандивыг хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивт тооцно:

11.1.1.банкны гүйлгээний баримтад хандивлагчийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл бүрэн тусгагдаагүй мөнгөн хандив;

11.1.2.буцах хаяг тодорхойгүй мөнгөн хандив;

11.1.3.хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандив;

11.1.4.хуульд заасан хэмжээнээс хэтэрсэн мөнгөн ба мөнгөн бус хандив.

11.2.Нам, эвсэл, нэр дэвшигчид хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг хүлээн авч, зарцуулах, ашиглахыг хориглоно.

Тайлбар: Буцах хаяг тодорхойгүй мөнгөн хандив гэдэгт хандивлагчийн нэр, регистрийн дугаар, банкны дансны дугаар зэрэг мэдээлэл зөрүүтэй байхыг хамруулж ойлгоно.

Арван хоёр. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаах, улсын /орон нутгийн/ орлогод шилжүүлэх

12.1.Нам, эвсэл, нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг дараах журмаар буцаан шилжүүлэх буюу улсын/ орон нутгийн/ орлого болгоно:

12.1.1.энэ журмын 11.1.1, 11.1.3-т заасан мөнгөн хандивыг сонгуулийн зардлын тайлан гаргахаас өмнө хандивлагч этгээдэд буцаан шилжүүлэх;

12.1.2.энэ журмын 12.1.1-д заасан хугацаанд буцаан шилжүүлээгүй болон энэ журмын 11.1.2-т заасан мөнгөн хандивыг улсын /орон нутгийн/ орлого болгох;

12.1.3.энэ журмын 11.1.4-т заасан хандивыг улсын/ орон нутгийн/ орлого болгох.

12.2.Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 12.1-д заасны дагуу улсын /орон нутгийн/ орлого болгох хандивыг улсын /орон нутгийн/ төсвийн орлогын нэгдсэн дансанд тушаана.

Арван гурав. Хуулиар зөвшөөрөгдөөгүй мөнгөн хандивыг ашигласанд тооцох

13.1.Нам, эвсэл, нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй мөнгөн хандивыг сонгуулийн зардлын дансанд хүлээн авснаас хойших сонгуулийн зардлын дансны үлдэгдэл нь уг мөнгөн хандивын хэмжээнээс бага байж болохгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДАЛ

Арван дөрөв. Сонгуулийн зардлын ангилал

14.1.Сонгуулийн зардлыг нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлалд заасан үзүүлэлтийг харгалзан ангилна.

14.2.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлыг дараах байдлаар ангилж, тайлагнана:

14.2.1.сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, тараах зардал;

14.2.2.нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал;

14.2.3.намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал;

- 14.2.4.сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал;
- 14.2.5.сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал:
 - 14.2.5.а.нэр дэвшигчийн ухуулах байрны түрээсийн зардал;
 - 14.2.5.б.нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал;
 - 14.2.5.в.нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал;
 - 14.2.5.г.нам, эвслээс зарцуулах томилолтын зардал;
 - 14.2.5.д.сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал.
- 14.2.6.сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал;
- 14.2.7.сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зардал;
- 14.2.8.өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх зардал;
- 14.2.9.энэ журмын 14.2.1-14.2.8-д хамаарахгүй бусад зардал.

Арван тав. Сонгуулийн зардал гаргах

15.1.Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах хүртэл хугацаанд энэ журмын 14.2-т заасан сонгуулийн зардалд зориулан сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргана.

15.2.Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данснаас гаргасан зарлага тус бүрийн зориулалт нь хүчин төгөлдөр анхан шатны баримтаар нотлогдсон байна.

15.3.Нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуулийн зардлын данснаас бэлнээр зарлага гаргахыг хориглоно.

15.4.Дараах зардлын нийт дүн нь сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй:

15.4.1.сонгуулийн зардлын данснаас зарлага болгосон энэ журмын 14.2-т заасан зардлын дүн;

15.4.2.сонгуулийн зардалтай холбоотой өр төлбөрийн дүн;

15.4.3.мөнгөн бус хандивын хэмжээ /энэ заалт нь зөвхөн нэр дэвшигчид хамаарна/.

15.5.Энэ журмын 15.4-т заасан зардлын дүн нь сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд илүү гарсан хэсэгтэй тэнцэх хэмжээний мөнгөн төлбөрийг нам, эвсэл, нэр дэвшигч улсын /орон нутгийн/ орлого болгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

Арван зургаа. Сонгуулийн зардлын тайлан

16.1.Сонгуулийн зардлын тайланг мөнгөн ба мөнгөн бус гэж ангилна.

16.2. Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлан гаргана.

16.3. Сонгуулийн зардлын тайланд нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуульд зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр ба зарлагын мэдээллийг бүрэн тусгана.

16.4. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах Маягт (1-9)-ын дагуу гаргаж, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ.

Арван долоо. Сонгуулийн зардлын тайлан гаргах

17.1. Хуулийн 56.3-т заасны дагуу нам, эвсэл санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ.

17.2. Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 17.1-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх сонгуулийн зардлын тайландаа дараах баримт бичгүүдийг хавсаргасан байна:

17.2.1. сонгуулийн зардлын дансны хуулга;

17.2.2. сонгуулийн зардлын тайланд тусгасан орлого, зарлагыг нотлох анхан шатны баримт;

17.2.3. байгуулсан гэрээ, хэлцлийн хуулбар;

17.2.4. нэр дэвшигч мөнгөн бус хандив авсан бол хандивын гэрээний хуулбар, хандивын гэрээний үнэлгээг тодорхойлсон нотлох баримт.

Арван найм. Сонгуулийн зардлын тайланг нийтэд мэдээлэх

18.1. Нам, эвсэл, нэр дэвшигч аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан сонгуулийн зардлын тайланг дараах хэлбэрээр нийтэд мэдээлнэ:

18.1.1. хуулийн 46.1.1, 46.1.2-т заасан цахим хуудаст байршуулах;

18.1.2. өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд байршуулах;

18.1.3. мэдээллийн сайт болон бусад олон нийтийн сүлжээнд байршуулах.

18.2. Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар энэ журмын 17.1-д заасны дагуу ирүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг цахим хуудастаа байршуулж, хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй нам, эвсэл, нэр дэвшигчийг нийтэд мэдээлнэ.

Арван ес. Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар сонгуулийн зардлын тайланг хянах, дүнг мэдээлэх

19.1. Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар энэ журмын 17.1-д заасны дагуу ирүүлсэн сонгуулийн зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ.

19.2. Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар сонгуулийн зардлын тайланг хянахдаа хуулийн 57.2.2-57.2.4-т заасан болон Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

19.3.Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар энэ журмын 19.2-т заасан бүрэн эрхийн дагуу мэдээлэл, баримт шаардсан тохиолдолд холбогдох нам, эвсэл, нэр дэвшигч, бусад иргэн, хуулийн этгээд мэдээлэл, баримтыг тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

19.4.Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 12.1, 15.5-д заасан мөнгөн хөрөнгийг улсын /орон нутгийн/ орлого болгоогүй тохиолдолд уг зөрчлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ.

Хорь. Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргах

20.1.Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд аудит хийх аудитын хуулийн этгээд нь Аудитын тухай хуульд заасны дагуу ажил төрөл, хувийн харилцаа холбоо, ашиг сонирхлын хувьд нам, эвсэл, нэр дэвшигчээс хараат бус байх шаардлагыг хангасан байна.

20.2.Сонгуулийн зардлын тайланд аудит хийхээр нам, эвсэл, нэр дэвшигчтэй гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд нь энэ журмын 20.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй талаарх мэдэгдэл, тайлбараа гэрээ байгуулснаас хойш 2 хоногийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт мэдэгдэнэ.

20.3.Аудитын хуулийн этгээд энэ журмын 20.2-т заасны дагуу гэрээ байгуулснаас хойш аливаа шалтгаанаар сонгуулийн зардлын тайланд аудит хийгээгүй, аудит хийхээс татгалзсан тохиолдолд энэ тухай мэдэгдэл, тайлбараа 2 хоногийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ.

20.4.Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын тайланд хийх аудитыг тухайн нам, эвсэл, нэр дэвшигчээс энэ журмын 16.4-д заасан маягтын дагуу гаргасан тайлан, энэ журмын 17.2-т заасан баримт бичиг болон анхан шатны баримтад үндэслэн хийнэ.

20.5.Холбогдох нам, эвсэл, нэр дэвшигч нь аудитын хуулийн этгээдээс шаардсан баримт бичиг, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж өгөх, эсхүл гуравдагч этгээдээс гаргуулж өгөх, аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах үүрэгтэй.

20.6.Аудитын хуулийн этгээд дараах асуудлуудын хүрээнд сонгуулийн зардлын тайланд аудит хийж дүгнэлт гаргана:

20.6.1.сонгуулийн зардлын тайланг батлагдсан маягтын дагуу иж бүрэн гаргаж, баталгаажуулсан эсэх;

20.6.2.сонгуулийн зардалд зарцуулсан намын болон нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн эх үүсвэр нь тодорхой, бодитой эсэх;

20.6.3.хүлээн авсан мөнгөн хандив нь хуулиар зөвшөөрөгдсөн, эх үүсвэр нь тодорхой, бодитой эсэх;

20.6.4.хүлээн авсан мөнгөн бус хандивын үнэлгээг бодитой тодорхойлсон эсэх;

20.6.5.сонгуулийн зардлын тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв тусгагдсан эсэх;

20.6.6.сонгуулийн зардлын зарцуулалт зориулалтын дагуу бодитой хийгдсэн бөгөөд анхан шатны баримтыг үндэслэн сонгуулийн зардлын тайланд үнэн зөв тусгагдсан эсэх.

20.7.Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын тайланд аудит хийхдээ Аудитын олон улсын стандартыг баримталж, Аудитын олон улсын стандарт 800 “Тусгай зорилго бүхий үзэл баримтлалд нийцүүлэн бэлтгэсэн санхүүгийн тайлангийн аудит”-г удирдлага болгон стандартын дагуу дүгнэлт гаргана.

20.8.Аудитын хуулийн этгээд аудитын үр дүн болон энэ журмын 20.7-д заасан дүгнэлтэд дэмжлэг болгох зорилгоор дараах бүтэц, агуулга бүхий аудитын дэлгэрэнгүй тайлан, дүгнэлтийн хамт Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ:

20.8.1.аудит хийсэн үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага;

20.8.2.аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт;

20.8.3.тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал;

20.8.4.материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар;

20.8.5.аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн;

20.8.6.илрүүлсэн зүйлсийн нэгтгэл, тайлбар;

20.8.7.санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗААЛТ

Хорин нэг. Сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад иргэд, олон нийтийн байгууллагын оролцоо

21.1.Сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад иргэд, олон нийтийн байгууллага дараах оролцоотой байна:

21.1.1.сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад оролцох, хөндлөнгийн ажиглалт хийх;

21.1.2.сонгуулийн зардалтай холбоотой гарсан зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдлийн талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад гомдол, мэдээлэл гаргах;

21.1.3.нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг үнэн зөв, бодитой гаргасан эсэх талаар дүн шинжилгээ хийх, санал, зөвлөмж гаргах.

Хорин хоёр. Хариуцлага

22.1.Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь сонгуулийн зардлын тайлангийн аудитын дүгнэлтийг үнэн зөв, бодитой гаргаагүй, илт худал дүгнэлт гаргасан, эсхүл хуульд заасныг зөрчиж аудит хийсэн аудитын хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.


22.2.Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар сонгуулийн зардлын тайлантай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйл баримт илэрсэн

тохиолдолд энэ тухай мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шалгуулна.

22.3.Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын хийсэн аудитын дүгнэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг Төрийн аудитын тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар зохицуулна.

-----oOo-----

20²⁰ оны 10 дугаар сарын 08-ны өдрийн
 А.Н.Х... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг гаргах маягт

НАМЫН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Маягт-1-1

Тайлан ирүүлсэн огноо:

... оны ...-р сарын ...-ны өдөр

НЭГ.НАМЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ			
Намын нэр: _____			
Регистрийн дугаар: _____			
Нэр дэвшүүлсэн хүний тоо: _____			
ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ			
Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр: _____			
Дансны дугаар: _____			
Гүйлгээ хийж эхэлсэн огноо: ... оны ...-р сарын ...-ны өдөр			
Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо: ... оны ...-р сарын ...-ны өдөр			
Эхний үлдэгдэл: _____			
ГУРАВ. НАМЫН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН			
	Үзүүлэлт	Дүн /төгрөгөөр/	Тоо
1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН			
1.1 Намын өөрийн хөрөнгө			
1.2 Хуулийн этгээдийн хандив			
1.3 Иргэний хандив			
2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН			
2.1 Сонгуулийн зардал			
	2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		
	2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал		
	2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		
	2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		
	2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		
	2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах		
	2.1.7 цахим орчин ашиглах зардал		
	2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал		
2.2 Бусад зардлын дүн			
3. ҮЛДЭГДЭЛ			
4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ			
5. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР			
6. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ			
6.1 буцаасан хандив			
6.2 улсын орлого болгосон хандив			
(Анхаарах: Дээрх бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна)			

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН: / Овог нэр /
 / Албан тушаал /
 ТАЙЛАН ХЯНАСАН: / Овог нэр /
 / Албан тушаал /

ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Маягт-1-2

Тайлан ирүүлсэн огноо:

... оны ...-р сарын ...-ны өдөр

НЭГ. ЭВСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		
Эвслийн нэр: _____		
Эвсэлд нэгдсэн намын тоо: _____		
Нэр дэвшүүлсэн хүний тоо: _____		
ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ		
Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр: _____		
Дансны дугаар: _____		
Гүйлгээ хийж эхэлсэн огноо: ... оны ...-р сарын ...-ны өдөр		
Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо: ... оны ...-р сарын ...-ны өдөр		
Эхний үлдэгдэл: _____		
ГУРАВ. ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН		
Үзүүлэлт	Дүн /тэгрөгөөр/	Тоо
1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН		
1.1 Намуудаас оруулсан өөрийн хөрөнгө		
Нам 1 /нэр/		
Нам 2 /нэр/		
Нам 3 /нэр/		
1.2 Хуулийн этгээдийн хандив		
1.3 Иргэний хандив		
2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		
2.1 Сонгуулийн зардал		
2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		
2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал		
2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		
2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		
2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		
2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах		
2.1.7 цахим орчин ашиглах зардал		
2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал		
2.2 Бусад зардлын дүн		
3. ҮЛДЭГДЭЛ		
4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ		
5. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР		
6. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ		
6.1 буцаасан хандив		
6.2 улсын орлого болгосон хандив		
(Анхаарах: Дээрх бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна)		

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН: / Овог нэр /
/ Албан тушаал /

ТАЙЛАН ХЯНАСАН: / Овог нэр /
/ Албан тушаал /

НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Маягт-1-3

Тайлан ирүүлсэн огноо:

... оны ...-р сарын ...-ны өдөр

НЭГ.НЭР ДЭВШИГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		
Ургийн овог:	_____	
Эцэг/эх/-ийн нэр:	_____	
Өөрийн нэр:	_____	
Регистрийн дугаар:	_____	
ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ		
Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр:	_____	
Дансны дугаар:	_____	
Гүйлгээ хийж эхэлсэн огноо:	... оны ...-р сарын ...-ны өдөр	
Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо:	... оны ...-р сарын ...-ны өдөр	
Эхний үлдэгдэл:	_____	
ГУРАВ. НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН		
Үзүүлэлт	Дүн /төгрөгөөр/	Тоо
1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН		
1.1 Нам/эвслээс оруулсан өөрийн хөрөнгө		
1.2 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө		
1.3 Хуулийн этгээдийн хандив		
1.3.1 Мөнгөн хандив		
1.3.2 Мөнгөн бус хандив		
1.4 Иргэний өгсөн нийт хандив		
1.4.1 Мөнгөн хандив		
1.4.2 Мөнгөн бус хандив		
2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		
2.1 Сонгуулийн зардал		
2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		
2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал		
2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		
2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		
2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		
2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах		
2.1.7 цахим орчин ашиглах зардал		
2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал		
2.2 Бусад зардлын дүн		
3. ҮЛДЭГДЭЛ		
4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ		
5. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР		
6. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ		
6.1 буцаасан хандив		
6.2 улсын орлого болгосон хандив		
<i>(Анхаарах: Дээрх бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна)</i>		

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/ Овог нэр /

/ Албан тушаал /

ТАЙЛАН ХЯНАСАН:

/ Овог нэр /

/ Албан тушаал /

НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-2/

№	Дансны дугаар, банкны нэр	Мөнгөн дүн	Огноо	Эх үүсвэр
1				
2				
3				
Нийт дүн				

Заавар: Мөнгөн дүн, огноо, эх үүсвэрийг гүйлгээ тус бүрээр нэг бүрчлэн бичнэ. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын дансандаа төвлөрүүлсэн нам, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийг ямар эх үүсвэрээс бүрдүүлсэн талаараа үнэн зөв, тодорхой бичнэ.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/

/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/

/албан тушаал /

МӨНГӨН ХАНДИВЫН ТАЙЛАН

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-3/

№	Хандивлагч		Хандивын хэмжээ /төгрөг/	Хандивын эх үүсвэр*	Хандивласан огноо
	Нэр	Регистрийн дугаар			
1	Иргэн				
2					
3					
		Дүн			
1	Хуулийн этгээл				
2					
3					
		Дүн			
		Нийт дүн			

*Хандивын эх үүсвэрийн мэдээллийг зөвхөн банкны гүйлгээний баримтад тусгагдсан байдлаар бичнэ.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/

/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/

/албан тушаал /

МӨНГӨН БУС ХАНДИВЫН ТАЙЛАН

Нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-4/

№	Хандивлагч		Хандивлагчийн хаяг	Эд хөрөнгө болон авсан үйлчилгээний мэдээлэл, хандивын зориулалт *	Гэрээний дугаар	Хандивын хэмжээ /хандивын гэрээнд зааснаар/	огноо
	Нэр	Регистрийн дугаар					
1	Иргэн						
2							
3							
		Дүн					
1	Хуулийн этгээл						
2							
3							
		Дүн					
	Нийт дүн						

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/ /албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/ /албан тушаал/

*Эзэмшүүлсэн, ашиглуулсан эд хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгө тохиолдолд улсын бүртгэлийн дугаар, тээврийн хэрэгсэл тохиолдолд улсын дугаар, бусад хөдлөх эд хөрөнгө тохиолдолд хөрөнгийн марк, нэр, эд хөрөнгө эзэмшсэн, ашигласан, авсан үйлчилгээний зориулалтыг тодорхой бичнэ.

Мөнгөн бус хандивын хэмжээг тодорхойлох жишээ:

- *Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэггүй этгээд дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр ашиглуулжээ. Энэ тохиолдолд нэр дэвшигч тухайн орон нутаг дахь ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг этгээдээс уг тоног төхөөрөмжийг ашиглахад ямар хөлс төлөхийг судлах замаар мөнгөн бус хандивын үнэлгээг тодорхойлно.*
- *Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэг этгээд нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр ашиглуулсан тохиолдолд уг мөнгөн бус хандивын хэмжээг тухайн этгээд энэ төрлийн үйлчилгээ үзүүлээд авдаг хөлсний дундаж үнэлгээгээр тодорхойлно.*

ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫН ТАЙЛАН

Нам /эвсэл/ нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-5/

№	Хандивлагч иргэн, хуулийн этгээдийн нэр /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивлагчийн регистрийн дугаар /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивын хэмжээ	Хандивын хэлбэр	Огноо	Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив гэж үзсэн тухай тайлбар
1						
2						
3						
Нийт дүн						

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/албан тушаал /

**ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫГ БУЦААСАН БУЮУ УЛСЫН ОРЛОГО
БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН**

Нам /эвсэл/ нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-6/

№	Хандивлагч иргэн, хуулийн этгээдийн нэр /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивлагчийн регистрийн дугаар /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивын хэмжээ	Шилжүүлгийн мэдээлэл		Буцаасан, улсын орлого болгосон тухай тайлбар	Огноо
				Буцаасан	Улсын орлого болгосон		
1							
2							
3							
Нийт дүн							

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/албан тушаал /

СОНГУУЛИЙН ЗАРДАЛТАЙ ХОЛБООТОЙ ӨГЛӨГИЙН ТАЙЛАН

Нам /эвсэл/ нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-7/

№	Зардлын зориулалтын тайлбар	Нэхэмжлэгч этгээдийн		Төлөх дүн	Төлөөгүй байгаа шалтгаан, цаашид авах арга хэмжээ
		Нэр	Регистрийн дугаар		
1					
2					
3					
Нийт дүн					

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/

/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/

/албан тушаал /

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ ТУС БҮРЭЭР ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-8/

№	Баримтын		Харилцагчийн нэр	Гүйлгээний утга	Дүн	Үүнээс: Орлогын ангилал						Тайлбар				
	Огноо	Нэр Дугаар				Иргэний өгсөн нийт хандив	Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив	Хандивын дансаар орсон бусад орлогын гүйлгээ	Нам, эвсэл, нэр дэвшигчийн хооронд	Банкны үйлчилгээ	Бусад					
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
							Нам/эвсэлээс оруулсан мөнгөн хөрөнгө	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	Мөнгөн хандив	Мөнгөн бус хандив	Мөнгөн хандив	Мөнгөн бус хандив	Нам, эвсэл, нэр дэвшигчийн хооронд	Банкны үйлчилгээ	Бусад	

Тайлан гаргасан:

Хянаж баталгаажуулсан:

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр, гарын үсэг, тамга

Аудитын хуулийн этгээдийн нэр, гарын үсэг, тамга

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ ТУС БҮРЭЭР ХИЙСЭН ЗАРЛАГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-9/

№	Баримтын			Харилцагчийн нэр	Гүйлгээний утга	Дүн	Үүнээс: Зардлын ангилал												Тайлбар		
	Огноо	Нэр	Дугаар				Сонгуулийн сурталчилганы материал хэвлүүлэх зардал	Сонгуулийн сурталчилганы материал тараах зардал	Нийтийн эзэмшлийн гудамж, талбай сонгуулийн сурталчилганы зургагчтай байрлуулах зардал	Намын далааг гудамж талбай байрлуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	Сонгогчидтой уулзалт, хурал цуглан хийх зардал	Ухуулах байрны түрээсийн зардал	Нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал	Нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал	Сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүл материал нийтлүүлэх зардал	Нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн тус бүр нэг цахим хуудаст шаардагдах зардал		Цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудаст шаардагдах зардал	Бусад цахим хуудсыг сурталчилгаанд ашиглах нам, эвсэл болон нэр дэвшигчийн зардал
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21
	Дүн																				


Тайлан гаргасан:

Хянаж баталгаажуулсан

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр, гарын үсэг, тамга

Аудитын хуулийн этгээдийн нэр, гарын үсэг, тамга

Дарга, тэргүүлэх аудиторын
20²⁰ оны 10 дугаар сарын 08-ны өдрийн
А/17 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ ТАЙЛАГНАХ ЗААВАР, АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

Заавар, аргачлал боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Дарга, тэргүүлэх аудиторын баталсан “Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалт, дэс дарааллыг нарийвчлан тодорхойлж, сонгуулийн зардлын тайлан гаргах бодлого, аргачлалыг энэ заавраар баталгаажуулав.

Зааврын зорилго, хамрах хүрээ

1.2. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэн бодит байдлаар гаргахад энэ заавар, аргачлалын зорилго оршино.

1.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон энэ заавар, аргачлалын 1.1-д заасан журмын дагуу сонгуулийн зардлын тайлан гаргах нам, эвсэл, нэр дэвшигч энэхүү заавар, аргачлалыг дагаж мөрдөнө.

1.4. Сонгуулийн зардлын тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээд энэ заавар, аргачлалыг шалгуур үзүүлэлт болгоно.

Батлагдсан маягтын талаарх ерөнхий мэдээлэл

1.5. Сонгуулийн зардлын тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудиторын 2020 оны А/17 дугаар тушаалаар баталсан “Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-д заасан маягтаар гаргаж баталгаажуулна.

1.6. Энэ заавар, аргачлалын 1.5-д заасан маягт тус бүрийн талаарх мэдээллийг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

1.6.1. Намын сонгуулийн зардлын тайлангийн хураангуй (**Маягт 1-1**), Эвслийн сонгуулийн зардлын тайлангийн хураангуй (**Маягт 1-2**), Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлангийн хураангуй (**Маягт 1-3**) хамаарна.

Тодруулга: Эдгээр маягууд нь ням, эвсэл, нэр дэвшигчийн талаарх ерөнхий мэдээлэл, дансны мэдээллээс гадна сонгуулийн зардлын дансаар орсон, гарсан бүх гүйлгээг ангилан нэгтгэх, сонгуулийн зардлын тайлангийн талаарх мэдээллийг нэгтгэж, баталгаажуулах зорилготой.

Нам, эвсэл, нэр дэвшигч өөрт хамаарах тайлангийн маягтыг сонгож, хураангуй тайлан бэлтгэж баталгаажуулна.

1.6.2. Нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн тайлан **(Маягт 2)**:

Тодруулга: Нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой болгож баримтжуулах зорилготой.

1.6.3. Мөнгөн хандивын тайлан **(Маягт 3)**, Мөнгөн бус хандивын тайлан **(Маягт 4)**:

Тодруулга: Нам, эвсэл, нэр дэвшигчид өгсөн хандивын талаар мэдээллийг нэгтгэж баримтжуулах зорилготой бөгөөд хандивлагчийг иргэн, хуулийн этгээдээр ангилан, хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллийг цуглуулна.

1.6.4. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивын тайлан **(Маягт 5)**:

Тодруулга: Энэ маягтаар хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивын талаарх мэдээллийг цуглуулахаас гадна хуулиар зөвшөөрөгдөөгүй гэж үзсэн үндэслэл тайлбарыг дэлгэрэнгүй авч, баталгаажуулахаар тооцсон.

1.6.5. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаасан буюу улсын орлого болгосон тухай тайлан **(Маягт 6)**:

Тодруулга: Хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивыг улсын орлого болгосон бол энэ талаарх мэдээллийг цуглуулж, баримтжуулах зорилготой.

1.6.6. Сонгуулийн зардалтай холбоотой өглөгийн тайлан **(Маягт 7)**:

Тодруулга: Сонгуулийн зардлын тайланг тайлагнах хугацаанаас хойш хийгдээгүй өр төлбөрийг зардлын зориулалт болон өр үүссэн шалтгаан тайлбартайгаар авч, баталгаажуулах зорилгоор энэ маягтыг боловсруулсан.

1.6.7. Сонгуулийн зардлын дансны гүйлгээ тус бүрээр хийсэн орлогын

дэлгэрэнгүй тайлан **(Маягт 8)**, Сонгуулийн зардлын дансны гүйлгээ тус

бүрээр хийсэн зарлагын дэлгэрэнгүй тайлан **(Маягт 9)**:

Тодруулга: Тус 2 маягтаар Сэлэнгэ аймаг дахь төрийн аудитын газарт бүртгүүлсэн сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын бүх гүйлгээг орлого, зарлагын ангиллаар задалж баталгаажуулахаас гадна дараагийн шатны дэлгэрэнгүй тайлан бэлтгэх үндэслэл болно. Энэ маягтаар бүртгэсэн орлого, зарлагын гүйлгээний нийт дүн нь харилцах дансны хуулгаар гарсан орлого, зарлагын нийт дүнтэй тэнцүү байна.

Хоёр. Сонгуулийн зардлын тайлангийн орлого, зарлагын ангилал

2.1. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлангийн орлого, зарлагыг энэ заавар, аргачлалын 1.5-д заасан журмын “зардлын тайлангийн хураангуй маягт”-аар¹ ангилан нэгтгэж, тайлагнана.

¹ Маягт 1-1, Маягт 1-2, Маягт 1-3

Орлогыг ангилах, бүртгэх

2.2. Намын сонгуулийн зардлын тайлангийн орлогын дүнг дараах байдлаар ангилж, нэгтгэнэ. Орлогын ангилал тус бүрд хамаарах орлогыг дараах заалтад үзүүлэв. Үүнд:

2.2.1. Намын өөрийн хөрөнгө;

2.2.2. Хуулийн этгээдийн хандив;

2.2.3. Иргэний хандив.

2.3. Эвслийн сонгуулийн зардлын тайлангийн орлогын дүнг дараах байдлаар ангилж, нэгтгэнэ Орлогын ангилал тус бүрд хамаарах орлого болон анхаарах асуудлыг дараах заалтад үзүүлэв. Үүнд:

2.3.1. Намуудаас оруулсан өөрийн хөрөнгө;

2.3.2. Хуулийн этгээдийн хандив;

2.3.3. Иргэний хандив.

2.4. Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлангийн орлогын дүнг дараах байдлаар ангилж, нэгтгэнэ.

2.4.1. Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө;

2.4.2. Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө;

2.4.3. Хуулийн этгээдээс өгсөн нийт хандив. Үүнд:

а. Мөнгөн хандив

б. Мөнгөн бус хандив

2.4.4. Иргэнээс өгсөн нийт хандив. Үүнд:

а. Мөнгөн хандив

б. Мөнгөн бус хандив

Тодруулга: Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны нийт орлогын гүйлгээг **Маягт 8**-д гүйлгээ тус бүрээр оруулах бөгөөд орлогын гүйлгээний дүнг орлогын дээрх ангилалд харгалзуулан хуваарилна. Ингэхдээ нэг гүйлгээний дүн 1-ээс дээш орлогын ангилалд хамаарч байгаа нь анхан шатны баримтаар нотлогдож байвал тохирох орлогын ангилалд салгаж оруулна.

Зарлагыг ангилах, бүртгэх

2.5. Намын сонгуулийн зардлын тайлангийн зарлагын дүнг дараах байдлаар ангилж, нэгтгэнэ. Зарлагын ангилал тус бүрд хамаарах зардал болон анхаарах асуудлыг дараах заалтад үзүүлэв. Үүнд:

2.5.1. Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах зардал:

- сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэхтэй холбоотой зардал;
- сонгуулийн сурталчилгааны материал тараахтай холбоотой зардал.

2.5.2. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал:

- зурагт самбар хэвлүүлэхтэй холбоотой зардал;
- зурагт самбарыг байрлуулах хөл, суурь, тогтоогч зэргийг түрээслэх, худалдаж авахтай холбоотой зардал;
- дэлгэц түрээслэх, худалдаж авахтай холбоотой зардал.

2.5.3. Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал:

- намын далбаа, уриа, таних тэмдэг бүхий хуудас хэвлүүлэх болон хувцас бусад бүтээгдэхүүн хийлгэхтэй холбоотой зардал.

2.5.4. Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал:

- Нэр дэвшигчээс болон нам, эвслийн удирдлагаас сонгуулийн тойрогт очиж /тойрон аялал/ сонгогчидтой хийсэн уулзалт, хурал, цуглааны үйл ажиллагаанд зориулан гаргасан сонгогчдод харилцаа холбооны болон бусад хэлбэрээр зар хүргэх, урилга хэвлүүлэх, заал, танхим, эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, бусад тоног, төхөөрөмж хөлслөх, худалдаж авахтай холбоотой зардлууд;
- Уулзалт, хурал, цуглаан хийхтэй холбоотой хоол, ундны зардал

Анхаарах: Гүйлгээний утга хэсэг дээр хэзээ, хаана болсон уулзалт, хурал, цуглааны талаар тодорхой бичнэ.

2.5.5. Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал:

- Нэр дэвшигчийн ухуулах байрны түрээсийн зардал;
- Нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал:
 - нам, эвслээс сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтанд олгосон хөлс, урамшуулал;
 - нэр дэвшигчээс менежер, шадар ухуулах, ухуулагч, ажиглагчид олгосон хөлс, урамшуулал.
- Нам, эвсэл, нэр дэвшигчээс тээврийн хэрэгслийн зардал:
 - нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны зориулалтаар ашигласан тээврийн хэрэгсэлд зарцуулсан шатахууны зардал;
 - нам, эвслийн удирдлагаас сонгуулийн тойрогт очих /тойрон аялал/-д гаргасан шатахууны зардал;
 - нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, менежер, шадар туслах, ухуулагчид олгосон шатахууны зардал;
 - Тээврийн хэрэгслийн түрээсийн зардал.
- Нам, эвслээс зарцуулах томилолтын зардал:

- Нам, эвслийг төлөөлөн үйл ажиллагаа явуулах эрх бүхий ажилтанд олгосон томилолтын зардал.
- Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны бусад зардал:
 - хүнсний, ахуйн хэрэглээний болон бусад хэрэгцээт бараа, материал, тоног төхөөрөмж худалдаж авсан зардал;
 - сонгууль эрхэлсэн байгууллага, түүний бүрэлдэхүүний ажлын хэрэгцээнд ашиглахаар эд хөрөнгө /зочид буудал, гэр гэх мэт/-ийн түрээсийн зардал;
 - бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр;
 - бичиг хэрэг, шуудан, харилцаа холбоо, интернэтийн төлбөр гэх мэт зардал;
 - Сонгууль эрхэлсэн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж гаргасан бусад зардал.

2.5.6. Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах:

- Радио, телевизээр дамжуулах сонгуулийн сурталчилгааны контент, шторк бэлтгэхтэй холбоотой зардал;
- Сонгуулийн сурталчилгааны контент, шторкийг радио, телевизээр нэвтрүүлэхтэй холбоотой зардал.

2.5.7. Цахим орчин ашиглах зардал:

- Домэйн нэр худалдаж авах, хостингийн төлбөр төлөх, цахим хуудас бүтээх, цахим хуудасны хөгжүүлэлтийн зардал;
- Цахим орчин дахь олон нийтийн сүлжээ, нам, эвсэл, нэр дэвшигч өөрийн болон бусад цахим хуудсаар дамжуулах сонгуулийн сурталчилгааны контент, шторк, бусад сурталчилгааны мэдээлэл бэлтгэхтэй холбоотой зардал;
- Контент, шторк, бусад сурталчилгааны мэдээллийг цахим орчин дахь олон нийтийн сүлжээ болон бусад цахим хуудсаар нийтэд түгээхтэй холбоотой зардал.

2.5.8. Өдөр тутмын болон бусад сонин, сэтгүүлд материал нийтлүүлэх зардал:

2.5.9. Бусад зардлын дүн

- Банкны үйлчилгээний хураамж;
- Сонгуулийн зардалд хамаарахгүй бусад зардал.

2.6. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны нийт зарлагын гүйлгээг **Маягт 9**-д гүйлгээ тус бүрээр оруулах бөгөөд зарлагын гүйлгээний дүнг энэ заавар, аргачлалын 2.5-д заасны дагуу ангилал тус бүрд харгалзуулан хуваарилна. Ингэхдээ нэг гүйлгээний дүн 1-ээс дээш зардлын ангилалд хамаарч байгаа нь анхан шатны баримтаар нотлогдож байвал тохирох зардлын ангилалд салгаж оруулна.

2.7. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансаар хийсэн зарлагын гүйлгээг бүртгэж, тайлагнахдаа Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан " Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд

нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал"-д заасан зардлын ангилалтай уялдуулна.

Гурав. Сонгуулийн зардлын тайлан бэлтгэх

Тайлан бэлтгэх дараалал

3.1. Сонгуулийн зардлын тайланг батлагдсан маягтаар энэ заавар, аргачлалын Хавсралт №1-д үзүүлсэн дарааллын дагуу бэлтгэж, баталгаажуулна.

Тодруулга: Батлагдсан маягтууд нь харилцан уялдаатай бөгөөд анхан шатны баримтад үндэслэсэн дэлгэрэнгүй бүртгэлээс орлого, зардлын зүйл тус бүрийг нэгтгэж, үр дүнг тайлагнана. Сонгуулийн зардлын тайлан гаргах үйл явцын зураглалыг Хавсралт №1-д үзүүлэв.

Батлагдсан маягтын уялдаа, харилцан хамаарал

3.2. Нам, эвсэл, нэр дэвшигчид батлагдсан маягтуудаас өөрт хамаарах маягтуудыг сонгож, иж бүрэн тайлагнана. Маягтад нам, эвсэл, нэр дэвшигч тус бүрд хамаарах маягыг тодорхойлсон болно.

3.3. Батлагдсан маягт тус бүрийн хоорондын уялдаа харилцан хамаарал, маягт нөхөх зааврыг зургаар харуулан эшлэл хийж, Хавсралт №2-т үзүүлэв.

Сонгуулийн зардлын тайланг баталгаажуулах, хүргүүлэх

3.4. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангийн хураангуй болон бусад холбогдох маягыг бэлтгэж, баталгаажуулахдаа нягтлан бодох бүртгэл, тайлагнал хариуцсан ажилтан батлагдсан маягтын "Тайлан бэлтгэсэн" хэсэгт, нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээд, нэр дэвшигч "Тайлан хянасан" хэсэгт тус тус овог нэр, албан тушаалаа бичиж, гарын үсэг зурж баталгаажуулна.

3.5. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг энэхүү заавар, аргачлал болон батлагдсан маягтын дагуу бэлтгэж, "Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам"-ын 16, 17 дугаар зүйлд заасан хугацаанд тайлагнана.

3.6. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлэхдээ батлагдсан маягтаас нам, эвсэл, нэр дэвшигч өөрт хамаарах маягтуудыг иж бүрэн бөглөж ирүүлэх бөгөөд тухайн маягтад оруулах мэдээлэл байхгүй байсан ч гарын үсэг зурж баталгаажуулна.

3.7. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг батлагдсан маягтаар гаргаж Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлэхдээ дараах байдлаар гаргаж ирүүлнэ. Үүнд:


№	Үзүүлэлт	Маягт бэлтгэж, ирүүлэх эсэх		
		Зардлын тайлан		
		Нам	Эвсэл	Нэр дэвшигч
1	Маягт 1-1	Тийм	Тийм	Тийм

2	Маягт 1-2	Үгүй	Үгүй	Үгүй
3	Маягт 1-3	Үгүй	Үгүй	Үгүй
4	Маягт 2	Тийм	Тийм	Тийм
5	Маягт 3	Тийм	Тийм	Тийм
6	Маягт 4	Үгүй	Үгүй	Үгүй
7	Маягт 5	Тийм	Тийм	Тийм
8	Маягт 6	Тийм	Тийм	Тийм
9	Маягт 7	Тийм	Тийм	Тийм
10	Маягт 8	Тийм	Тийм	Тийм
11	Сонгуулийн зардлын дансны банкны хуулга	Тийм	Тийм	Тийм
12	Маягт 9	Тийм	Тийм	Тийм
13	Хараат бус аудитын дүгнэлт	Тийм	Тийм	Тийм
14	Бусад нэмэлт тайлбар тодруулга	Тийм	Тийм	Тийм

3.8. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцогч нам, эсвэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан, тодруулга, тэдгээрийг дэмжих нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт материалыг Архивын тухай хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу архивлана.

* * *

Хавсралт № 1 Сонгуулийн тайлан бэлтгэх үйл явцын зураглал



Хавсралт № 2 Батлагдсан маягтуудыг нөхөх заавар, харилцан уялдаа

НАМЫН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Тайлан ирүүлсэн огноо: _____

Маягт-1-1

Тайлангийн төрөл: _____

Эцсийн тайлан

/төгрөгөөр/

НЭГ. НАМЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ			
1.1 Намын нэр:			
1.2 Нэр дэвшүүлсэн хүний тоо:		1.3 Регистрийн дугаар:	
ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ			
1.1 Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр:	Улаанбаатар хотын банк	1.4 Гүйлгээ хийж эхэлсэн огноо:	
1.2 Дансны дугаар:		1.5 Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо:	
1.3 Эхний үлдэгдэл:		1.7 Аймаг, нийслэл, сум, дүүрэгт зардлын данстай эсэх:	Тийм
1.8 Хэрэв тийм бол: Орон нутгийн салбарын нийт дансны тоо:		1.8.1 Нийт орлого:	
		18.2 Нийт зарлага:	
ГУРАВ. НАМЫН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН			
	Үзүүлэлт	Дүн	Тоо
1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН		-	
1.1 Намын өөрийн хөрөнгө			
1.2 Хуулийн этгээдийн хандив			
1.3 Иргэний хандив			
2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		0	
2.1 Сонгуулийн зардал		0	
2.1.1	сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах <i>нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн</i>		
2.1.2	<i>сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал</i>		
2.1.3	<i>намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал</i>		
2.1.4	<i>сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал</i>		
2.1.5	<i>сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал</i>		
2.1.6	<i>сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах</i>		
2.1.7	<i>цахим орчин ашиглах зардал</i>		
2.1.8	<i>өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал</i>		
2.2	Бусад зардлын дүн		
3. ҮЛДЭГДЭЛ			
4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ			
5. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР			
6. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ			
6.1	буцаасан хандив		
6.2	улсын орлого болгосон хандив		

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/ Албан тушаал /

/ Овог нэр /

ТАЙЛАН ХЯНАСАН:

/ Албан тушаал /

/ Овог нэр /

Жич: Дээрх бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна

ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Тайлан ирүүлсэн огноо: _____

Маягт-1-2

Тайлангийн төрөл: _____

Эцсийн тайлан

/төгрөгөөр/

НЭГ. НАМЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ				
1.1	Эвслийн нэр:			
1.2	Эвсэлд нэгдсэн намын тоо:		1.3	Эвсэлд нэр дэвшүүлсэн хүний тоо
ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ				
2.1	Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр:	Улаанбаатар хотын банк	2.2	Дансны дугаар:
2.4	Гүйлгээ хийж эхэлсэн огноо:		2.5	Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо:
2.3	Эхний үлдэгдэл:			
ГУРАВ. НАМЫН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН				
Үзүүлэлт			Дүн	Тоо
1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН			-	
1.1	Намуудаас оруулсан өөрийн хөрөнгө		-	
	Нам 1 /нэр/			
	Нам 1 /нэр/			
	Нам 1 /нэр/			
1.2	Хуулийн этгээдийн хандив			
1.3	Иргэний хандив			
2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН				
2.1	Сонгуулийн зардал			
2.1.1	сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах			
2.1.2	нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал			
2.1.3	намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал			
2.1.4	сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал			
2.1.5	сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал			
2.1.6	сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах			
2.1.7	цахим орчин ашиглах зардал			
2.1.8	өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал			
2.2	Бусад зардлын дүн			
3. ҮЛДЭГДЭЛ				
4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ				
5. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР				
6. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ				
6.1	буцаасан хандив			
6.2	улсын орлого болгосон хандив			

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/ Албан тушаал /

/ Овог нэр /

ТАЙЛАН ХЯНАСАН:

/ Албан тушаал /

/ Овог нэр /

Жич: Дээрх бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна

НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Тайлан ирүүлсэн огноо: _____

Маягт-1-3

Тайлангийн төрөл: _____

Эцсийн тайлан

/төгрөгөөр/

НЭГ. НАМЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ				
	1.1 Ургийн овог:		1.2 Эцэг эхийн нэр:	
	1.3 Өөрийн нэр:		1.4 Регистрийн дугаар:	
ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ				
	2.1 Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр:	2.2 Дансны дугаар:	2.3 Эхний үлдэгдэл:	2.4 Гүйлгээ хийж эхэлсэн огноо:
	ХААН банк			2.5 Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо:
ГУРАВ. НАМЫН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН				
	Үзүүлэлт		Дүн	Тоо
1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН				
	1.1 Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнө		-	
	1.2 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө			
	1.3 Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив		-	
	1.3.1 Мөнгөн хандив			
	1.3.2 Мөнгөн бус хандив			
	1.4 Иргэний хандив		-	
	1.4.1 Мөнгөн хандив			
	1.4.2 Мөнгөн бус хандив			
2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН				
	2.1 Сонгуулийн зардал		-	
	2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах			
	2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал			-
	2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал			
	2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал			
	2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал			
	2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах			
	2.1.7 цахим орчин ашиглах зардал			
	2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал			
	2.2 Бусад зардлын дүн			
3. ҮЛДЭГДЭЛ				
4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ				
5. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР				
6. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ				
	6.1 буцаасан хандив			
	6.2 улсын орлого болгосон хандив			

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/

///

ТАЙЛАН ХЯНАСАН:

/

///

Жич: Дээрх бүх мэдээлэл дансны хуулиаар баталгаажна

НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр _____

/Маягт 2/

№	Дансны дугаар, банкны нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Огноо	Эх үүсвэр
А	1	2	3	4
	Нийт дүн	0		

Энэ баганад нам, эвсэл, нэр дэвшигчийн ямар данснаас шилжүүлсэн талаарх мэдээллийг оруулна

Маягт 8-ын 7 дугаар баганын мэдээлэл энэ маягтад орно.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/ Албан тушаал // Овог нэр /

ТАЙЛАН ХЯНАСАН:

/ Албан тушаал // Овог нэр /

Заавар: Мөнгөн дүн, огноо, эх үүсвэрийг гүйлгээ тус бүрээр нэг бүрчлэн бичнэ. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын дансандаа төвлөрүүлсэн нам, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийг ямар эх үүсвэрээс бүрдүүлсэн талаараа үнэн зөв, тодорхой бичнэ.

МӨНГӨН ХАНДИВЫН ТАЙЛАН

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-3/

№	Хандивлагч		Хандивын хэмжээ /төгрөгөөр/	Хандивын эх үүсвэр*	Хандивласан огноо	
	Нэр	Регистрийн дугаар				
А	1	2	3	4	5	6
1	Иргэн					
2						
3						
		Дүн	Маягт 8-ын 9, 11 дүгээр баганын мэдээлэл энэ маягтад орно.	0		
1	Хуулийн этгээд					
2						
3						
		Дүн		0		
		Нийт дүн		0		

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/ Албан тушаал // Овог нэр /

ТАЙЛАН ХЯНАСАН:

/ Албан тушаал // Овог нэр /

Заавар: 5 дугаар багана дахь хандивын эх үүсвэрийн мэдээллийг зөвхөн банкны гүйлгээний баримтад тусгагдсан байдлаар бичнэ.

Жич: Энэ маягтад хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивыг оруулахгүй бөгөөд эдгээр хандивын талаарах мэдээллийг Маягт 5-д оруулна

МӨНГӨН БУС ХАНДИВЫН ТАЙЛАН

Нэр дэвшигчийн нэр _____

^/Маягт-4/

№	Хандивлагч		Хандивлагчийн хаяг	Эд хөрөнгө болон авсан үйлчилгээний мэдээлэл, хандивын зориулалт	Гэрээний дугаар	Хандивын хэмжээ /төгрөгөөр/	огноо	
	Нэр	Регистрийн дугаар						
A	1	2	3	4	5	6	7	8
1	Иргэн							
2								
3								
	Дүн						0	
1	Хуулийн этгээд							
2								
3								
	Дүн						0	
	Нийт дүн						0	

Маягт 8-ын 10, 12 дүгээр баганын мэдээлэл энэ маягтад орно.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/ Албан тушаал // Овог нэр /

ТАЙЛАН ХЯНАСАН:

/ Албан тушаал // Овог нэр /

Заавар: 5 дугаар багана дахь хандивын зориулалт хэсэгт эзэмшүүлсэн, ашиглуулсан эд хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгө тохиолдолд улсын бүртгэлийн дугаар, тээврийн хэрэгсэл тохиолдолд улсын дугаар, бусад хөдлөх эд хөрөнгө тохиолдолд хөрөнгийн марк, нэр, эд хөрөнгө эзэмшсэн, ашигласан, авсан үйлчилгээний зориулалтыг тодорхой бичнэ.

7 дугаар багана дахь хандивын хэмжээ нь хандивын гэрээнд зааснаар байна.

Мөнгөн бус хандивын хэмжээг тодорхойлох жишээ:

§ Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэггүй этгээд дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр ашиглуулжээ. Энэ тохиолдолд нэр дэвшигч тухайн орон нутаг дахь ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг этгээдээс уг тоног төхөөрөмжийг ашиглахад ямар хөлс төлөхийг судлах замаар мөнгөн бус хандивын үнэлгээг тодорхойлно.

Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэг этгээд нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр ашиглуулсан тохиолдолд уг мөнгөн бус хандивын хэмжээг тухайн этгээд энэ төрлийн үйлчилгээ үзүүлээд авдаг хөлсний дундаж үнэлгээгээр тодорхойлно.

Жич: Энэ маягтад хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивыг оруулахгүй бөгөөд эдгээр хандивын талаарх мэдээллийг Маягт 5-д оруулна

ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫН ТАЙЛАН

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-5/

№	Хандивлагч иргэн, хуулийн этгээдийн нэр	Хандивлагчийн регистрийн дугаар	Хандивын хэмжээ	Хандивын хэмжээ /төгрөгөөр/	Огноо	Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив гэж үзсэн тухай тайлбар
А	1	2	3	4	5	6
1						
2						
3						
	Нийт дүн			0		

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/ Албан тушаал // Овог нэр /

ТАЙЛАН ХЯНАСАН:

/ Албан тушаал // Овог нэр /

Заавар: 1, 2 дугаар баганын мэдээллийг байгаа хэмжээгээр бөглөнө

Жич: Маягт 8-ын 9-12 дугаар багана дахь хандивын талаарх мэдээллээс хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивын талаарх мэдээллийг түүвэрлэн энэ маягтад хуримтлуулж бүртгэнэ

**ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫГ БУЦААСАН БУЮУ УЛСЫН ОРЛОГО
БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН**

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-6/

№	Хандивлагч иргэн, хуулийн этгээдийн нэр	Хандивлагчийн регистрийн дугаар	Хандивын хэмжээ /төгрөгөөр/	Шилжүүлгийн мэдээлэл		Буцаасан, улсын орлого болгосон тухай тайлбар	Огноо
				Буцаасан	Улсын орлого болгосон		
А	1	2	3	4	5	6	7
1							
2							
3							
	Нийт дүн		0	0	0		

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/ Албан тушаал // Овог нэр /

ТАЙЛАН ХЯНАСАН:

/ Албан тушаал // Овог нэр /

Заавар: 1, 2 дугаар баганын мэдээллийг байгаа хэмжээгээр бөглөнө

Жич: Маягт 5-ын мэдээллээс буцаасан болон улсын орлого болгосон мэдээллийг Маягт 9-ийн 22 дугаар багана дахь мэдээллээс энэ маягтад хуримтлуулж бүртгэнэ

СОНГУУЛИЙН ЗАРДАЛТАЙ ХОЛБООТОЙ ӨГЛӨГИЙН ТАЙЛАН

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-7/

№	Зардлын зориулалтын тайлбар	Нэхэмжлэгч этгээдийн		Төлөх дүн /төгрөгөөр/	Төлөөгүй байгаа шалтгаан, цаашид авах арга хэмжээ
		Нэр	Регистрийн дугаар		
А	1	2	3	4	5
1					
2					
3					
	Нийт дүн			0	

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/ Албан тушаал // Овог нэр /

ТАЙЛАН ХЯНАСАН:

/ Албан тушаал // Овог нэр /

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ ТУС БҮРЭЭР ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр:

/Маягт-8/

№	Баримтын		Харилцагчийн нэр	Гүйлгээний утга	Дүн	Үүнээс: Орлогын ангилал							Тайлбар	
	Огноо	Нэр				Дугаар	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	Иргэний өгсөн нийт хандив	Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив	Хандивын дансаар орсон бусад орлогын гүйлгээ	Банкны үйлчилгээ	Бусад		
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	16
					Энэ баганын мэдээллийг Маягт 2-т оруулах бөгөөд 7 дугаар баганын нийт дүн Маягт 2-ын 2 дугаар баганын нийт дүнтэй тэнцүү байна. 8 дугаар баганын мэдээлэл энд хамаарна.	9 дүгээр баганын мэдээллийг Маягт 3-ын "иргэн" хэсэгт оруулна. Энэ маягтын 9 дүгээр баганын дүн маягт 3-ын Маягт 3-ын 4 дүгээр багана дахь "иргэн" хэсгийн дүн болон Маягт 5 дахь хулээн зөвшөөрөхгүй хандивын дүнтэй тэнцүү байна. Мөнгөн бус хандив ижил зарчимтай	11 дүгээр баганын мэдээллийг Маягт 3-ын "хуулийн этгээд" хэсэгт оруулна. Энэ маягтын 11 дүгээр баганын дүн маягт 3-ын 4 дүгээр багана дахь "хуулийн этгээд" хэсгийн дүн болон Маягт 5 дахь хулээн зөвшөөрөхгүй хандивын дүнтэй тэнцүү байна. Мөнгөн бус хандив ижил зарчимтай	0	0	0	0	0	0	0
Дүн						0	0	0	0	0	0	0	0	0

Орлогын нийт дүн 7-15
дугаар баганын нийт дүнгийн
нийлбэртэй тэнцүү байх
ёстой

ТАЙЛАН БЭЛЛТГЭСЭН:

ТАЙЛАН ХЯНАСАН:

/ Албан тушаал // Овог нэр /

/ Албан тушаал // Овог нэр /

Жич: Дээрх бүх мэдээлэл дансны хуульгаар баталгаажна

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ ТУС БҮРЭЭР ХИЙСЭН ЗАРЛАГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр:

/Маягт-9/

№	Баримтын			Харилцагчийн нэр	Гүйлгээний утга	Дүн	Үүнээс: Зардлын ангилал											Тайлбар					
	Огноо	Нэр	Дугаар				сонгуулийн сурталчилгааны материал хэвүүлэх, сонгогчдод тараах	сонгуулийн сурталчилгааны материал тараах зардал	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зуратг самбар байрлуулах зардал	Намын далааг гудамж талбайд байрлуулах, танки тэмдэг, уриа ашиглах зардал	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглан хийх зардал	Ухуулах байрны түрээсийн зардал	нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал	нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал	нам, эвсэлээс зарцуулах томилолтын зардал	сонгуулийн сурталчилгаанд зарцуулах зардал	Сонгууль эрхэлсэн байшуулагын үйл ажиллагааны зардал		Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	нам, эвсэл болон нэр дэвшигчийн өөрийн тус бүр нэг цахим хуудаст шаардагдах зардал	цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудаст шаардагдах зардал	бусад цахим хуудаст сурталчилгаанд ашиглах нам, эвсэл болон нэр дэвшигчийн зардал
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23
						0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
					Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН: / Албан тушаал // Овог нэр /
ТАЙЛАН ХЯНАСАН: / Албан тушаал // Овог нэр /

Жич: Дээрх бүх мэдээлэл дансны хуулиар баталгаажна